



ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН
ТУГИЙН ОДОНТ
АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2024 оны 01 сарын 05 өдөр

Дугаар 1/02а

Улаанбаатар хот

Хамтын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.2, Эрүүл мэндийн Сайдын 2020 оны 02 дугаар сарын 08-ний өдрийн А/69 дүгээр тушаал, Арьсны өвчин судлалын үндэсний төвийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5,2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн салбарын 2024-2025 оны хамтын хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор ажлын бус цагаар шөнийн ээлжид ажиллаж буй эмнэлгийн ажилтанд оройн хоол, өглөөний цайг үнэ төлбөргүй олгосугай.

2. Эмнэлгийн ажилчдын цай, хоолны зардлыг нэг хүний 6,500 (зургаан мянга таван зуу) төгрөг, эмчилгээний хоолны зардлыг нэг хүний 7,260 (долоон мянга хоёр зуун жар) төгрөгт багтаан төвийн урсгал төсвийн хоол, хүнсний зардлаас гаргахыг Санхүүгийн албаны дарга (Б.Мядаг)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал (Т.Баярмаа)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Ц.УРАНЧИМЭГ